



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 1127

Улаанбаатар хот

### Сургалт зохион байгуулах тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалт, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 3.4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Жуулчдад зориулсан гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн дунд "Гар урлал ба борлуулалтын менежмент" сэдэвт сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Сургалтын төсөв болох 106250 /нэг зуун зургаан мянга хоёр тавин/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Сургалтыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА

1150500085

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 05 сарын 09-ний өдрийн  
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**“ГАР УРЛАЛ БА БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ”  
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

**Зорилго:** Гар урлалын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бэлэг дурсгалын үйлдвэрлэл эрхэлдэг байгууллага болон иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, аялал жуулчлалын салбараас иргэд ашиг олох боломжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар, дизайн, хаяг, шошго, тайлбар, сав баглаа боодлыг жуулчдын хэрэгцээнд нийцүүлэх чиглэлээр гар урчууд, бэлэг дурсгалын зүйлс үйлдвэрлэгчдийн мэдлэгийг дээшлүүлэхэд энэхүү сургалтын зорилго оршино.

**Сургалтын хөтөлбөр:**

Хичээлийн цаг	Хичээлийн сэдэв	Илтгэл тавих хүн
09:00-09:30	Бүртгэл	
09:30-10:00	Нээлтийн ажиллагаа	-Нийслэлийн Аялал жуулчлалын газар -Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
10:00-11:00	Маркетингийн 4P-г бизнест амжилттай хэрэглэх нь (бүтээгдэхүүн, үнээ хэрхэн зөв тогтоох, хуваариалтын аргууд, барааг идэвхижүүлэх нь)	Я.Оюунтунгалаг /ШУТИС, УТДС-ийн тэргүүлэх профессор/
11:00-12:00	Гар урлалын бүтээгдэхүүний борлуулалтын систем	Я.Оюунтунгалаг /ШУТИС, УТДС-ийн тэргүүлэх профессор/
12:00-12:30	<b>Завсарлага</b>	
12:30-13:30	Гарурчуудын өнөөгийн байдал, дэлхийн чиг хандлага/тэдний өмнө тулгамдсан асуудал, алдаа оноо, гар урлалын бүтээлийн сав, баглаа боодол, дизайн/	Ц.Цэнд-Аюуш /Цагаан алт-ноосон эдлэлийн гар урлалыг дэмжих төв, МҮХАҮТ-ын гар урлалын зөвлөлийн гишүүн/
13:30-14:30	“Бүтээгдэхүүний чанар ба дэлхийд өрсөлдөх чадвар /бүтээгдэхүүний борлуулалт, стандарт хэм хэмжээ/	Ц.Цэнд-Аюуш /Цагаан алт-ноосон эдлэлийн гар урлалыг дэмжих төв, МҮХАҮТ-ын гар урлалын зөвлөлийн

		гишүүн/
14.30-15.00	Гэрчилгээ гардуулах	Нийслэлийн Аялал жуулчлалын газар Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв

**Хамрах хүрээ:** Гар урчууд, бэлэг дурсгалын үйлдвэрлэл эрхлэгчид

**Зохион байгуулагч:** Нийслэлийн Аялал жуулчлалын газар, нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв

**Хугацаа:** 2014 оны 5-р сарын 16-ний өдөр 10.00-14.30цаг хүртэл зохион байгуулна.


**Хүрэх үр дүн:** Гар урлалын бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлсийн чанар, өрсөлдөх чадвар сайжирч, борлуулалт өснө. Аялал жуулчлалаар дамжуулан нийслэлийн иргэдэд хүрэх эдийн засгийн өгөөж нэмэгдэнэ.

**Болох газар:** Нийслэлийн Аялал жуулчлалын газрын Мэдээлэл, сурталчилгааны төвийн сургалтын танхимд

**Бүртгэх газар:** Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 20.4 оны 05 сарын 09 өдрийн  
А/24 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**“ГАР УРЛАЛ БА БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ”  
СУРГАЛТЫНТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Багшийн зардал /Я.Оюунтунгалаг/	1	30000	30000
2	Багшийн зардал /Ц.Цэнд-Аюуш/	1	50000	50000
3	Гэрчилгээ	15	1750	26250
	<b>Нийт дүн</b>			<b>106250</b>

ТӨСӨВ ЗОХИОСОН:

НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш.УНДАРМАА

ХЯНАСАН:

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П.АРИУНАА